



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/А26

Булган сум

CHAMP MEDIA GROUP ХХК сайттай
гэрээ байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны II/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэн ажиллах “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн явц, гарсан үр дүнг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор CHAMP MEDIA GROUP ХХК сайттай гэрээ байгуулах зардалд 3,000,000 (гурван сая0 төгрөгийн шаардагдах зардлыг баталсугай.

2. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ